



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2021.6.25 № 19/3342
танай _____-ны № _____-т

Санал ирүүлэх тухай

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗАР, ТӨРӨЛЖСӨН
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ,
ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВИЙН
ДАРГА ЗАХИРАЛ НАРТ

Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах, удирдах, санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг цогцоор нь зохицуулах зорилгоор тус яамнаас “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай” хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд эрүүл мэндийн байгууллага бүрээс өргөн хүрээнд нээлттэй санал авах шаардлагатай байна.

Иймд өөрийн харьяа эрүүл мэндийн бүх байгууллагаас дараах чиглэлээр санал авч нэгтгэн, Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газарт 2021 оны 08 сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, нэр томьёо
2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, түүний чиг үүрэг, хамрах хүрээ
3. Иргэний эрүүл мэндийг хамгаалахад иргэн, гэр бүл, хамт олон, аж ахуйн нэгж байгууллагын хүлээх үүрэг, оролцоо, зохион байгуулалт
4. Эрүүл мэндийг дэмжих, хамгаалахад төр, хувийн хэвшлийн түншлэл, эрүүл мэндийг дэмжихэд төрийн бус байгууллагын хүлээх үүрэг, оролцоо, дэмжлэг
5. Нийтийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцооны зохион байгуулалт
6. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх үндэсний тогтолцооны зохион байгуулалт
7. Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх, үндэсний тогтолцооны зохион байгуулалт
8. Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохицуулалт
9. Эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нийгмийн хүчин зүйлс, эрсдлийг бууруулах, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зохицуулалт
10. Нийгмийн эрүүл мэндийн судалгаа, шинжилгээ, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих, сургалт сурталчилгааны ерөнхий зохицуулалт
11. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн нэгдсэн зохицуулалт
12. Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын зохицуулалт, эрүүл мэндийг дэмжих, боловсрол олгох үйл ажиллагааны зохицуулалт
13. Эрүүл ахуй, орчны эрүүл мэндийн зохицуулалт, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний зохицуулалт


144216811

14. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, хүний нөөц, тасралтгүй хөгжил
15. Нийтийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, сурталчилгааны зохицуулалт, хязгаарлалт, татвартай холбоотой энэхүү хуулийн төслийг дагалдан холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал
16. Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэхтэй холбоотой энэхүү хуулийн төслийг дагалдан бусад хуулийн төсөлд оруулах нэмэлт өөрчлөлтийн санал
17. Дээрх ангилалд тусгагдаагүй нэмэлт санал

Дархлаажуулалтын тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай, Эрүүл ахуйн тухай, Тамхины хяналтын тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай гэх мэт нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой бусад бие даасан хуулиар зохицуулсан харилцааг давхцуулахгүй байх, аль болох тусламж, үйлчилгээний зохицуулалтыг үр дүнтэйг үр ашигтай зохион байгуулахад чиглэсэн байхыг зөвлөж байна.

Түүнчлэн санал ирүүлсэн байгууллагын жагсаалт, оролцсон хүний тоог нэгтгэж, тухайн саналыг тусгах хэрэгцээ шаардлага, үндэслэлийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх баримт нотолгоо, судалгааны үр дүн, тайлан гэх мэт материал байгаа бол хавсаргана уу.

САЙД



С.ЭНХБОЛД